



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 17 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 17 дугаар хуралдааныг 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 17 дугаар хуралдаанаар /2025-08-19/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 13 (Тогтоол №172-184, 2025-08-19) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 17 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 13 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 13 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 172 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Телко ХХК: Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 173 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Нексмайнд ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 174 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Вентана констракшн ХХК; Ривизм ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 175 тоот тогтоолыг баталж, тогтоолын

хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Голден зоне ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – БНСУ/, Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–Австрали Улс/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 176 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Гэрэлт хүрэх оргил ХХК, 43200077 тоот: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–АНУ/) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 177 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийн үйлчилгээний нэрд (Монзах ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 12900123 тоот тусгай зөвшөөрлийн “ONTV” телевизийн үйлчилгээний нэрийг “NTV SPORT” болгох) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 178 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Нексмайнд ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт “Төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэх” 12910022 тоот тусгай зөвшөөрлийг Контент Дистрибушн ХХК-д) шилжүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Бунадо ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 179 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Бунадо ХХК: Орхон аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000133 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Эгон ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 180 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Эгон ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 12900106 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Ишилан ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 181 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Ишилан ХХК: Орхон аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000112 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 182 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд 5 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 183 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.8} дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 184 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (ЖСММ БГБХ нөхөрлөл: Баян-Өлгий аймгийн Өлгий, Бугат, Улаанхус, Цэнгэл сумдын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” /550МГц - 590МГц/ 23410030 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунган тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-08-23